



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1, 30.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ажиллах цагийн хязгаар шинэчлэн тогтоох тухай” А/847, 2024 оны “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/244 дүгээр захирамж, 2025 оны “Захирамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/357 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2026 оны 01 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох 3 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 1 хуулийн этгээдийг хоёрдугаар хавсралтаар, спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 1 хуулийн этгээдийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Номин), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Т.Баатар), дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Э.Энхсүвд)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
 2026 оны 02 дүгээр сарын 04-ны өдрийн
 АМД дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
 ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Дижитал концепт ХХК	Г.Чинзориг	CU	6531342	Ая тухтай дэлгүүр	24 цаг	5	Тасганы овоо, /15150/, Их тойруу гудамж 25 байр 101 тоот
2	Премиум Нэксус ХХК	Б.Гантиг	GS	6155804	Ая тухтай дэлгүүр	24 цаг	9	Дэнж 1 гудамж 0013 тоот
3	Эрдэнэ Очир Хайрхан ХХК	Л.Мөнх-Эрдэнэ	Грийн март	5455839	Хүнсний дэлгүүр	06:00-00:00	20	Хувьсгалчид Г18 гудамж 409А тоо

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2026 оны 02 дүгээр сарын 01-ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Их дэлгэц трейд ХХК	Ц.Оюунцэцэг	Сөүлмэт	2765179	Баар/караоке	14:00-04:00	3	Энхтайваны өргөн чөлөө, 27/1 тоот

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2026 оны .02 дүгээр сарын .04-ны өдрийн
МАН дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

СПИРТТИЙН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДААГААР ҮЙЛЧЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Грассланд стэппэ ХХК	Б.Багадэлгэр	BB steak	7121201	Кафе	11:00-22:00	1	2-р 40 мянгат 40-р байр 16, 17 тоот